

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/02/НА/-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл.....
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/195
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/76 дугаар тушаалаар баталсан дүрмийн 3.1.11-д Төв аймгийн Эрүүл мэндийн төвүүдийг санхүүгийн удирдлагаар хангах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн тайлан гаргах, нэгтгэх ажиллагааг тодорхойлон тусгаж өгсөн байна. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж 99,6 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитыг хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,293,412,226.40	946,528,915.50
34	УРЬДЧИЛГАА	00.00	74,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	74,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,293,412,226.40	872,528,915.50
351	Түүхий эд материал	503,988,689.50	463,061,861.14
35110	Тусгай зориулалттай материал	2,295,700.00	1,326,900.00
35130	Эм боох материал	501,692,989.50	461,734,961.14
354	Хангамжийн материал	789,423,536.90	409,467,054.36
35410	Бичиг хэргийн материал	2,341,554.00	1,969,950.00
35420	Аж ахуйн материал	1,163,550.00	847,250.00
35440	Түлш, шатах тослох материал	3,878,987.00	5,713,752.00
35450	Барилгын засварын материал	5,009,700.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	777,029,745.90	400,936,102.36
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	853,989,289.27	819,460,084.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	853,989,289.27	819,460,084.10
392	Биет хөрөнгө	695,597,889.27	661,068,684.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,815,865.55	618,815,865.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-92,123,197.21	-115,145,642.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	276,851,297.00	276,851,297.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	263,751,497.64	271,679,549.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-200,105,044.70	-186,350,311.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,837,591.10	93,687,695.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-88,228,347.21	-84,472,639.64
393	Биет бус хөрөнгө	158,391,400.00	158,391,400.00
39301	Програм хангамж	2,057,500.00	1,672,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,057,500.00	-1,672,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	158,391,400.00	158,391,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,147,401,515.67	1,765,988,999.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,147,327,792.14	1,765,915,276.07
51	Засгийн газрын хувь оролцоо	2,147,327,792.14	1,765,915,276.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,142,232,871.77	1,142,232,871.77
51101	Өмч: - төрийн	983,841,471.77	983,841,471.77
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	158,391,400.00	158,391,400.00
512	Хуримтлагдсан үр дүн	765,787,446.40	384,456,474.28
51210	Өмнөх үеийн үр дүн	765,787,446.40	765,868,990.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-381,412,516.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,307,473.97	239,225,930.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,147,327,792.14	1,765,915,276.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,413,705,585.95	3,808,317,593.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,083,846,359.95	1,050,213,668.37
120	Нийтлэг татварын бус орлого	2,083,846,359.95	1,050,213,668.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,329,859,226.00	2,758,103,925.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,227,692,900.00	2,539,314,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,227,692,900.00	2,539,314,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,166,326.00	218,789,925.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	38,994,402.00	59,573,715.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	19,717,966.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,098,924.00	128,293,244.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,073,000.00	11,205,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,686,682,149.46	2,791,109,818.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,686,682,149.46	2,791,109,818.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,337,830,317.01	1,468,439,873.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	565,501,764.04	883,690,097.34
210101	Үндсэн цалин	351,696,366.00	477,890,117.66
210102	Нэмэгдэл	95,835,069.04	268,170,440.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,545,000.00	42,149,999.88
210104	Урамшуулал	77,425,329.00	95,479,539.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,566,269.51	111,681,783.61
210201	Тэтгэврийн даатгал	50,993,831.89	76,491,731.08
210202	Тэтгэмжийн даатгал	5,872,227.28	8,999,027.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,556,661.74	7,128,821.61
210204	Ажилгүйдлийн даатгал	1,103,958.58	1,732,925.98
210205	Эрүүл мэндийн даатгал	11,039,590.02	17,329,277.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,081,222.00	84,098,708.16
210301	Гэрэл, цахилгаан	6,029,413.00	6,582,785.43
210302	Түлш, халаалт	68,072,136.00	72,836,434.73
210303	Цэвэр, бохир ус	9,979,673.00	4,679,488.00
2104	Хангамж, бараа материалын зардал	350,717,175.83	125,862,042.86
210401	Бичиг хэрэг	7,416,681.00	8,341,004.00
210402	Тээвэр, шатахуун	53,269,970.00	47,099,739.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,886,786.00	4,338,116.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,417,220.00	7,096,370.00
210408	Бараа материал акалсны зардал	275,246,518.83	58,506,813.75
2105	Нормативт зардал	21,726,260.00	17,066,939.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,726,260.00	17,066,939.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,395,289.00	48,844,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	560,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,947,619.00	352,770.00
210604	Урсгал засвар	33,447,670.00	47,932,130.00
2107	Томилолт, зочны зардал	37,612,700.00	36,667,915.00
210702	Дотоод албан томилолт	37,612,700.00	36,667,915.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,287,978.00	11,312,821.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,180,465.00	4,368,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,220,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	735,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	322,500.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,512,000.00	4,360,500.00
210807	Газрын төлбөр	426,513.00	419,621.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,941,658.63	149,214,666.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,708,302.00	70,665,935.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,116,550.00	11,234,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,116,806.63	67,314,131.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,348,851,832.45	1,322,669,945.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,305,752,503.00	1,312,905,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	416,227,900.00	828,922,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	886,026,703.00	478,291,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,497,900.00	5,691,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	9,764,245.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,764,245.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	43,099,329.45	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,099,329.45	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,727,023,436.49	1,017,207,775.22
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,537,075,083.57	1,398,390,291.54
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	105,000.02
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,537,075,083.57	-1,398,390,291.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	189,948,352.92	-381,182,516.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,334,859,226.00	2,758,103,925.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,334,859,226.00	2,758,103,925.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,227,692,900.00	2,539,314,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,227,692,900.00	2,539,314,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,166,326.00	218,789,925.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	38,994,402.00	59,573,715.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	8,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	19,717,966.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,098,924.00	127,953,840.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,073,000.00	3,544,404.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,334,859,226.00	2,665,587,925.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,334,859,226.00	2,665,587,925.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	986,007,393.55	1,342,687,980.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	565,501,764.04	883,690,097.34
210101	Үндсэн цалин	351,696,366.00	477,890,117.66
210102	Нэмэгдэл	95,835,074.00	268,170,440.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,544,998.36	42,149,999.88
210104	Урамшуулал	77,425,325.68	95,479,539.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,566,269.51	111,681,783.61
210201	Тэтгэврийн даатгал	50,993,831.89	76,491,731.08
210202	Тэтгэмжийн даатгал	5,872,227.28	8,999,027.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,556,661.74	7,128,821.61
210204	Ажилгүйдлийн даатгал	1,103,958.58	1,732,925.98
210205	Эрүүл мэндийн даатгал	11,039,590.02	17,329,277.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,081,222.00	84,098,708.16
210301	Гэрэл, цахилгаан	6,029,413.00	6,582,785.43
210302	Түлш, халаалт	68,072,136.00	72,836,434.73
210303	Цэвэр, бохир ус	9,979,673.00	4,679,488.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,889,526.00	63,257,320.11
210401	Бичиг хэрэг	5,773,500.00	4,729,500.00
210402	Тээвэр, шатахуун	41,577,900.00	49,384,504.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,886,786.00	4,338,116.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,171,340.00	4,325,200.00
2105	Нормативт зардал	20,435,300.00	9,465,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,404,900.00	9,075,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,030,400.00	390,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,724,370.00	50,548,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,315,000.00	1,132,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,401,070.00	00.00
210604	Урсгал засвар	27,008,300.00	49,416,940.00
2107	Томилолт, зочны зардал	37,612,700.00	36,667,915.00
210702	Дотоод албан томилолт	37,612,700.00	36,667,915.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,063,678.00	11,270,421.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,255,978.00	4,764,121.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,220,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	735,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	171,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	59,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,287,700.00	4,360,500.00
210807	Газрын төлбөр	351,000.00	172,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,132,564.00	92,007,095.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,696,014.00	89,194,995.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,436,550.00	2,812,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,348,851,832.45	1,322,899,944.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,305,752,503.00	1,312,905,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	416,227,900.00	828,922,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	886,026,703.00	478,291,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,497,900.00	5,691,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,099,329.45	9,994,244.78

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,764,245.03
213304	Хөрөнгийн	43,099,329.45	229,999.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	92,516,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	92,516,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	92,516,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	92,516,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	74,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	18,516,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-92,516,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,142,232,871.77	239,307,473.97	575,912,817.01	1,957,453,162.75
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,142,232,871.77	239,307,473.97	575,912,817.01	1,957,453,162.75
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	189,948,352.92	189,948,352.92
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,142,232,871.77	239,307,473.97	765,787,446.40	2,147,327,792.14
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,142,232,871.77	239,307,473.97	765,787,446.40	2,147,327,792.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	81,543.95	81,543.95
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,142,232,871.77	239,307,473.97	765,868,990.35	2,147,409,336.09
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-81,543.95	00.00	-81,543.95
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-381,182,516.32	-381,182,516.32
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,142,232,871.77	239,225,930.02	384,686,474.03	1,766,145,275.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,539,766,300.00	2,529,549,754.97	-10,216,545.03	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,539,766,300.00	2,529,549,754.97	-10,216,545.03	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,226,408,300.00	1,216,644,054.97	-9,764,245.03	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,733,600.00	866,163,160.34	-570,439.66	99.9
210101	Үндсэн цалин	484,456,900.00	477,890,117.66	-6,566,782.34	98.6
210102	Нэмэгдэл	270,257,700.00	250,643,503.80	-19,614,196.20	92.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,949,000.00	42,149,999.88	-5,799,000.12	87.9
210104	Урамшуулал	64,070,000.00	95,479,539.00	31,409,539.00	149.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,117,400.00	109,490,914.36	-5,626,485.64	95.1

210201	Тэтгэврийн даатгал	78,279,800.00	75,001,941.43	-3,277,858.57	95.8
210202	Тэтгэмжийн даатгал	9,209,400.00	8,823,757.85	-385,642.15	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,367,500.00	6,988,606.10	-378,893.90	94.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,841,900.00	1,697,872.12	-144,027.88	92.2
210205	Эрүүл мэндийн даатгал	18,418,800.00	16,978,736.86	-1,440,063.14	92.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,456,000.00	84,098,708.16	-357,291.84	99.6
210301	Гэрэл, цахилгаан	9,602,700.00	6,582,785.43	-3,019,914.57	68.6
210302	Түлш, халаалт	67,329,100.00	72,836,434.73	5,507,334.73	108.2
210303	Цэвэр, бохир ус	7,524,200.00	4,679,488.00	-2,844,712.00	62.2
2104	Хангамж, бараа материалын зардал	35,144,200.00	34,481,316.11	-662,883.89	98.1
210401	Бичиг хэрэг	4,530,000.00	4,529,500.00	-500.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	21,217,700.00	20,808,500.00	-409,200.00	98.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,568,400.00	4,338,116.11	-230,283.89	95.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	672,800.00	480,000.00	-192,800.00	71.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,155,300.00	4,325,200.00	169,900.00	104.1
2105	Нормативт зардал	8,545,000.00	7,895,700.00	-649,300.00	92.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,549,900.00	7,505,700.00	-44,200.00	99.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	995,100.00	390,000.00	-605,100.00	39.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,392,100.00	66,384,940.00	-7,160.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,168,000.00	19,168,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	47,224,100.00	47,216,940.00	-7,160.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	7,036,800.00	7,036,800.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	7,036,800.00	7,036,800.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тө	10,337,400.00	9,350,421.00	-986,979.00	90.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үй	3,565,900.00	2,844,121.00	-721,779.00	79.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	735,100.00	735,000.00	-100.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,500.00	171,500.00	00.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,300.00	59,300.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,625,600.00	4,360,500.00	-265,100.00	94.3
210807	Газрын төлбөр	172,000.00	172,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32645800.00	31742095.00	-903,705.00	97.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,982,800.00	28,929,995.00	-52,805.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,663,000.00	2,812,100.00	-850,900.00	76.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1313358000.00	1312905700.00	-452,300.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,313,358,000.00	1,312,905,700.00	-452,300.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн т	829,355,500.00	828,922,900.00	-432,600.00	99.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	478,291,500.00	478,291,200.00	-300.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,711,000.00	5,691,600.00	-19,400.00	99.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,539,766,300.00	2,539,314,000.00	-452,300.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,539,766,300.00	2,539,314,000.00	-452,300.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,539,766,300.00	2,539,314,000.00	-452,300.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00	57,281.00	
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00	7,323.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00	4,090.00	
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00	45,868.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, бодлого, шийдвэр, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улс, аймгийн эдийг засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн салбарыг аймгийн хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хүн амд эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ хүргэх, иргэдэд нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг зохицуулах, төлөвлөх, прогнозчилох, удирдах хяналт үнэлгээ хийх ажиллагааг хариуцан ажилладаг Эрүүл Мэндийн Яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 45 батлагдсан орон тоотой боловч 2023 онд 39 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна: Үүнд удирдах ажилтан 1, гүйцэтгэх 9, үйлчилгээний 29

Тус Эрүүл мэндийн газар нь 2023 оноос эхлэн өөрийн үйл ажиллагааны дүрэмд өөрчлөлт оруулж харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх, үүрэг даалгавар өгч, биелэлтийг шаардах, хариуцлага тооцох эрх үүрэгтэй болсон.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 оны 11 сард Төв аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтанд хамрагдаж 93%-тай дүгнэгдсэн. Мөн 2023 онд Төв аймгийн санхүү хяналт, аудитын албанаас 2021-2022 оны санхүүгийн тайланд хяналт шалгалт хийж шилэн дансны мэдээлэл, нягтлан бодох бүртгэл, анхан шатны бүртгэл хөтлөлт шаардлагын түвшинд гэж дүгнэсэн байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон/ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 381,412.5 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар *буурсан* байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа		74,000.0	74,000.0
Бараа материал	1,293,412.2	872,528.9	(420,883.3)
Үндсэн хөрөнгө	853,915.6	819,386.4	(34,529.2)
Нийт хөрөнгө	2,147,327.8	1,765,915.3	(381.412.5)
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,147,327.8	1,765,915.3	(381.412.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,147,327.8	1,765,915.3	(381.412.5)

Дээрхи хүснэгтээс харахад: Урьдчилгаа дансны үлдэгдэл 74,000.0 мянган төгрөг байгаа нь Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр ирсэн хөрөнгө байна. Энэ санхүүжилтийн эх үүсвэрийг Төв аймгийн худалдан авах ажиллагааны газарт тусламж үйлчилгээний автомашин авахаар шилжүүлж, энэ гүйлгээг дараа тооцоо хийхээр урьдчилгаа зардал дансанд бичсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 420,883.3 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь: а/Улсын төсвийн хөрөнгөөр 63,337.6 мянган төгрөгийн, өөрийн хөрөнгөөр 21,316.8 мянган

төгрөгийн хангамжийн бараа материалыг худалдан авсан. Хандиваар 1,035,839.7 мянган төгрөгийн эм боох материал ба бусад хангамжийн бараа материал хүлээн авсан, бусад газраас 390.0 мянган төгрөгийн түлш шатахуун авсан байна.

б/Байгууллагын өөрийн үйл ажиллагаанд 84,639,7 мянган төгрөгийн хангамжийн бараа материалыг зарцуулсан .

в/Төсөвт /ЭМТ/ байгууллагуудад 2023 онд 1,391,778.9 мянган төгрөгийн, бусад байгууллагад 6,452.0 мянган төгрөгийн эм, боох материал болон бусад хангамжийн бараа материалыг шилжүүлсэн.

г/ Тус байгууллага нь 2023 онд 58,506.8 мянган төгрөгийн эм боох материал болон бусад хангамжийн бараа материалыг акталж данснаас хассан зэргээс шалтгаалан бараа материал дансны үлдэгдэл буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс үлдэгдэл 34,529.2 мянган төгрөгөөр буурсан нь а/ Улсын төсвөөр 18,516.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан. б/ Хандиваар 11,460.9 мянган төгрөгийн Машин тоног төхөөрөмж авсан байна. Мөн 2,913.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тавилгыг Мэргэжлийн хяналтын газраас шилжүүлж авсан.

в/Тайлант онд тус Төв аймгийн иргэдийн хурлын 2023 оны 02 сарын 01-ний өдрийн хуралдаанаас гаргасан 08 тоот тогтоолоор тус байгууллагын 38 нэр төрлийн 33,496.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан байна.

г/ Тайлант онд 67,314.1 мянган төгрөгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулсан.

Дээрх ажил гүйлгээнээс шалтгаалан үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 34,529.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр дансанд үлдэгдэл байхгүй.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,539,766.3 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төслийг 2,539,766.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2,539,766.3 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,539,314.0 мянган төгрөг улсын төсвөөс, дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 127,953.8 мянган төгрөг, Засгийн Газрын нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 19,718.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3,544.4 мянган төгрөг, ОУ-ын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 8,000.0 мянган төгрөг нийт 2,758,103.9 мянган төгрөгөөр төсвийг бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,674,109.6 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардлыг 9,764.2 мянган төгрөгөөр, цалин хөлс нэмэгдэл

түүнтэй холбоотой зардал 5,627.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71603	Эрүүл мэндийн бодлого удирдлага	1,213,125.0	1,203,410.6	9,714.4	99,2
83112	Хөтөлбөр төслийн арга хэмжээ	13,283.3	13,233.5	49.9	99,6
80802	Бусад урсгал шилжүүлэг,	1,313,358.0	1,312,905.7	452.3	99,9
	Д ү н	2,539,766.3	2,529,549.8	10,216.6	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд дээд шатны төсвийн захирагчаас 127,953.8 мянган төгрөг, Засаг даргын нөөц сангаас 19,718.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,544.4 мянган төгрөг, Олон Улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 8,000.0 мянган төгрөг нийт 218,789.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого төвлөрүүлсэн. Энэхүү орлогыг доорхи зүйлд зарцуулсан байна Үүнд: Цалин, цалин хөлстэй холбоотой зардалд 19,717.8 мянган төгрөг, Хангамжийн болон норматив бараа материалын зардалд 30,826.0 мянган төгрөг, Томилолт зочны зардал 29,631.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 62,185.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 2,200.0 мянган төгрөг тус тус зарцуулж нийт 144,559.9 мянган төгрөгийг зарцуулсан гэж тайланд тусгажээ.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

1 хөтөлбөр 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71603	2023,12,31	Үндсэн үйл ажиллагаа	99,2	1,213,125.0	1,203,410.6
2	71411-83112	2023,12,31	Хөтөлбөр төслийн арга хэмжээ	94,6	13,283.3	13,233.5
3	71411-80802	2023,12,31	Урсгал шилжүүлэг	99,9	1,313,358.0	1,312,905.7

Хэрэгжилт хангалтгүй биелэгдсэн арга хэмжээ байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан төсвийн зардлын эдийн засгийн ангиллын дагуу нарийвчлан 24 арга хэмжээ бүхий 158.8 сая төгрөгийн төлөвлөгөө батлан мөрдөн ажилласан байна.

Төлөвлөгөөгөөр Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын дагуу 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй түлш шатах тослох материалд харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулах бусад арга хэмжээ нь шууд худалдан авахаар төлөвлөгджээ.

Түлш шатах тослох материалын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн ажиллагаа цахимаар зохион байгуулагдаж 1 оролцогч тендерт орж, Петровис ХХК тендерийн болзлыг хангасны дагуу гэрээ байгуулсан байна.

Шууд худалдан авалтыг дараах компаниудаас хийсэн байна. Үүнд: Нар сар энэрэл Мандуухай цэцэн ХХК, Монгол шуудан ТӨҮГ, БТМ ХХК, Шовх оргил ХХК зэргээс бичиг хэрэг хангамжийн бараа материал худалдан авчээ.

Ундрам төв ХХК ,Зуун мод гол ХХК –зэрэг байгууллагаас хоол үйлдвэрлэлийн хүнсний бараа материалыг худалдаж авчээ.

Эм, эмийн хэрэгсэл, боох материалаа УБ хотын эм ханган нийлүүлэх Монгол эм импекс ХХК аас худалдан авдаг байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/36 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Эрүүл мэндийн

газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,185,000.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 43,700.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 34,960.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус Эрүүл мэндийн газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг авлага үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулсан байна. Үүнд: Цалин хөлс болон түүнтэй холбоотой даатгалын зардлыг 6,196.9 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материал болон нормативт зардлыг 1,312.2 мянган төгрөгөөр нийт 7,509.1 мянган төгрөгийн зардлыг хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийг шалгахад 2023 онд Төв аймгийн Эрүүл мэндийн газрын Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 156 мэдээллийг байршуулж 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг анхааруулж зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. 2023 онд Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь шатах тослох материалын худалдан авах ажиллагаанд 21,217.7 мянган төгрөгийн нээлттэй тендер зарласан боловч тухайн үед архивын нэгж болгон хадгалаагүй байв. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтас хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэж заасан

заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 онд ТБОНӨХБАУХАТ хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 158.8 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 325.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. Энэ нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 44.1/ Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	900.0	1	900,0	100,0
Албан шаардлага	6	49,949.2	6	49,949.2	100,0
Зөвлөмж	3	316,838.1	3	316,838.1	100.0
Нийт дүн	10	367,687.3	10	367,687.3	100.0

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Урьд оны аудитын 1 төлбөр, 6 шаардлага, 3 зөрчил нийт 10 зөрчлийг хэрэгжсэн гэж үзлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байгаа нь эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах, татварын эрсдэл үүсэх тул дараагийн аудитаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар албан хариуцлагатай холбоотой 3 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага:

1. 2023 оны 01 дугаар сард Төв аймгийн эрүүл мэндийн газрын дүрэмд өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн үүнтэй уялдан өөрийн онцлогт тохирсон байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасан

заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4,2,1.1-д Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй” 4,2,1-д “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн Төв аймгийн Эрүүл мэндийн газрын дарга. С.Мөнхтуяа, нягтлан бодогч Б.Төмөрчөдөр нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Төв аймгийн Эрүүл мэндийн газрын харьяа Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төв, Баян-Өнжүүл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд тус тус татгалзах дүгнэлт гаргасан байна.Энэ нь Төв аймгийн эрүүл мэндийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/06 дугаар тушаалаар баталсан дүрмийн 3.1.11-д /Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүгийн удирдлагаар хангах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн мэдээ нэгтгэх, үнэлэлт, дүгнэлт өгөх/мөн дүрмийн 3.1.12-т/Салбарын болон байгууллагын санхүүгийн бүртгэлийг хянах, санхүү хөрөнгө нөөцийг хуваарилах, зөв зарцуулах, хяналт тавих, санхүүгийн тайлан гаргах, нэгтгэх/ гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь:

МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын” 4,2,1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн Төв аймгийн Эрүүл мэндийн газрын дарга. С.Мөнхтуяа, нягтлан бодогч Б.Төмөрчөдөр нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3. /2022, 2023 он/ жил дараалан санхүүгийн аудитын тайлангаар татгалзах дүгнэлт авсан Төв аймгийн Баян-өнжүүл сумын Эрүүл мэндийн төвийн дарга Я.Нарансайханд ямар ч хариуцлага тооцоогүй. Энэ нь Төв аймгийн эрүүл мэндийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/06 дугаар тушаалаар баталсан дүрмийн 2.1-д /Харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх, үүрэг даалгавар өгч, биелэлтийг шаардах, хариуцлага тооцох/ гэсэн заалт,мөн дүрмийн 3.2.2-т/ Харьяа эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн бодлого зохицуулалтыг оновчтой зохион байгуулж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах/ гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын” 4,2,1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн Төв аймгийн Эрүүл мэндийн газрын дарга С.Мөнхтуяа, нягтлан бодогч Б.Төмөрчөдөр нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж:

Урьдчилж гарсан данстай холбоотой

1. 2023 оны 11 сард Эрүүл Мэндийн Яамнаас Эрдэнэсант суманд хуваарилагдах түргэн тусламжийн автомашины үнэ 74,000.0 мянган төгрөгийг 2023 оны 12 сард Төв аймгийн худалдан авах ажиллагааны газрын дансанд шилжүүлсэн боловч 2024 оны 03

дугаар сарын 01 хүртэл ямар ч асуудал шийдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх” заалт, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгийг төсвийн жилд нь багтаан оновчтой, үр ашигтай байхаар зарцуулах.

Хөрөнгийн данстай холбоотой

2. Тусгай зориулалтын бараа материалын дансанд ариутгалын аппарат, автомайзер буюу уурын ариутгагч, мананцар үүсгэгч аппарат зэрэг 17 ширхэг 25,178.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байгааг цаашид залруулж үндсэн хөрөнгө дансанд бүртгэх. Энэ зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д/ Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан гаргах” заалт, Сангийн яамны 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус дагаж мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн яамны 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажиллах

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өөрийн онцлогт тохирсон НБББББ шинэчилэн боловсруулаагүй	1				1								
Байгууллагын дүрмийн 3.1.11, 3.1.12-т заасан заалтуудыг биелүүлээгүй	1				1								
Байгууллагын дүрмийн 2.1-д болон 3.2.2-т заасан заалтыг тус тус биелүүлээгүй	1				1								
ЭМЯ-наас хуваарилсан хөрөнгийг ХААГ-т шилжүүлсэн боловч зохих эзэндээ тусламж үйлчилгээний автомашин болж очоогүй	1	74,000.0						1	74,000.0				
Хангамжийн бараа материалын дансанд үндсэн хөрөнгийг дансалсан	1	25,178.1						1	25,178.1				
Дүн	5	99,178.1			3			2	99,178.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах 159 мэдээллээс 156 мэдээллийг хугацаанд байршуулж 3 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	1						1	
ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 158,8 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 325,0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн	1	325,000.0					1	325,000.0
21,217.7 мянган төгрөгийн нээлттэй тендер зарласан боловч тухайн үед архивын нэгж болгон хадгалаагүй байв	1	21,217.7					1	21,217.7
Дүн	3	346,217.7					3	346,217.7
Нийт дүн	8	445,395.8					5	445,395.8

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn